

АРДЧИЛСАН НАМД САНАЛ ӨГӨӨРЭЙ

11-р сарын 4-ний Мягмар гарагт

Муж улсын хэмжээнд нэр дэвшигчид

Арлингтон дүүргийн нэр дэвшигчид

**Таны сонгуулийн хуудсан дээрх Ардчилсан намынхан
Виржиниа мужид үр дүн авчрах нь**

- Арлингтон дүүргийн бүх нийтийн төлөө дуу хоолойгоо хүргэх
- Эрүүл мэндийн үйлчилгээ, орон сууц, эрчим хүчний зардлыг бууруулах
- Холбооны албан хаагчид болон гэрээт ажилчдыг хамгаалах
- Улсын сургуулиудаа бэхжүүлэх
- Гэр бүлүүдийн аюулгүй байдлыг хангах

Abigail Spanberger

Амбан захирагч

Абигэйл Виржиниа мужийг амьдрахад болон гэр бүл өсгөхөд илүү боломжийн, хүртээмжтэй газар болгохын тулд амбан захирагчид нэр дэвшиж байна. Тэрээр Ричмондын ойролцоох дундаж давхаргын гэр бүлд өсөж, холбооны хууль сахиулах байгууллагад ажил амьдралаа эхэлсэн бөгөөд хүүхдийн бэлгийн мөлжлөгийн хэрэг мөрдөх, хар тамхины хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажиллаж байв.

Конгрессын гишүүн байхдаа Абигэйл Трамп болон Байдены үед ч, улс төрийн үл ойлголцол дунд ч бодит үр дүнд хүрч чадсан бөгөөд Виржиниа мужийн хоёр намын түншлэлтэйгээр ажилласан гишүүнээр үнэлэгдсэн юм.

Ghazala Hashmi

Дэд амбан захирагч

Газала Хашми бол 30 шахам жилийн туршлагатай боловсролын ажилтан, ээж, мөн Виржиниагийн мужийн сенатор бөгөөд карьерынхаа туршид орхигдсон, дэмжлэг хэрэгтэй иргэдийн төлөө тэмцэж ирсэн нэгэн юм.

Мужийн сенаторын хувьд Газала улсын сургуулиудад бүрэн санхүүжилт олгуулах, боломжийн үнэтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг хамгаалах, нөхөн үржихүйн эрхийг хамгаалахын төлөө ажилласан билээ.

Jay Jones

Ерөнхий прокурор

Норфолк хотод насан туршдаа амьдарч буй, хоёр хүүгийн эцэг Жэй Жонс нь Ерөнхий прокурорын туслах, мөн Төлөөлөгчдийн танхимын гишүүнээр ажиллаж байсан туршлагатай нэгэн юм.

Жэй нь галт зэвсгийн лоббитой тэмцэж, гэр бүлүүдийг аюулгүй байлгах, корпорацуудыг шүүхэд өгч хүнсний үнийн өсөлтийг тогтоон барих, мөн томоохон банкнууд болон мөлжлөгт байшингийн эзэдтэй үр дүнтэй тэмцэж чадсан юм.

Patrick Hope

Төлөөлөгчдийн танхим 1-р тойрог

2009 оноос хойш Виржиниа мужийн 1-р тойргийн төлөөлөгчөөр ажиллаж буй Патрик Хөуп 9 дэх удаагаа дахин сонгогдохоор нэр дэвшиж байна. Хууль тогтоогчийн замналынхаа турш тэрээр 115-аас дээш хуулийг батлуулж, эрүүл мэндийн үйлчилгээ, иргэний эрх, бууны хүчирхийлэлтэй тэмцэхэд манлайлан оролцжээ. Арлингтон дүүрэгт үйлчилж байгаагаараа бахархдаг Патрик өөрийн туршлага, үр дүнтэй ажлаа үргэлжлүүлэн, иргэний эрхийг хамгаалж, хүн бүрд аюулгүй, эрүүл ирээдүйг бүтээхийн төлөө таны дэмжлэгийг хүсэж байна.

Adele McClure

Төлөөлөгчдийн танхим 2-р тойрог

Адел МакКлюр дахин сонгогдож, орон сууц болон хүүхэд харах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, бууны хүчирхийлэлтэй тэмцэх, нөхөн үржихүйн эрх чөлөөг хамгаалах зэрэг чухал асуудлыг үргэлжлүүлэн хамгаалахаар нэр дэвшиж байна. Тэрээр сонгогчид, идэвхтнүүд, олон нийтийн удирдагчидтай гар нийлж ажиллан, эрхийг тэлэх, саадыг арилгах, Арлингтон болон муж даяар зайлшгүй шаардлагатай үйлчилгээнд хүртээмжийг нэмэгдүүлэх нөлөөтэй хууль тогтоомжуудыг батлуулахаар ажиллаж байна.

Alfonso Lopez

Төлөөлөгчдийн танхим 3-р тойрог

Альфонсо Лопез нь боловсрол, байгаль орчны хамгаалал, орон сууцны хүртээмж, эдийн засгийн хөгжил болон найрсаг хамт олныг бий болгох зэрэг Арлингтоны иргэдэд чухал асуудлуудын хүрээнд 30 гаруй жилийн хууль тогтоох туршлагатай. Обамагийн засаг захиргаанаас томилогдсон улс төрийн этгээд асан, Кейнийн засаг захиргааны танхимын түвшинд томилогдсон этгээд, Төлөөлөгчдийн танхимын Ардчилсан намын бүлгийн зохион байгуулагч тэрээр хүн бүрд итгэл найдвар өгч, хэнийг ч орхигдуулахгүй байх Виржиниа муж улсыг бүтээхийн төлөө өдөр бүр хичээн ажилладаг билээ.

Takis Karantonis

Арлингтоны Хорооны Зөвлөл

Такэс Карантонис дахин сонгогдож, Арлингтоны иргэдийн төлөө Хорооны Зөвлөлд ажиллахаар нэр дэвшиж байна. Тэрээр цагаачид болон холбооны ажилчдыг дарангуйллын дарамтаас хамгаалж, орон сууцны хямралтай тэмцэх, эдийн засгийн шударга ёсыг ахиулах, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээ авах, бүх нийтийн боловсролыг дэмжих, хариуцлагатай засаглал болон хүчирхэг нийгмийн хамгааллын тогтолцоог бий болгоход төвлөрөн ажиллаж байна. Хамгийн гол нь тэр Арлингтоныг хүн бүр бахархалтайгаар “гэр” гэж дуудах ардчилсан, шударга, хүртээмжтэй газар болгохын төлөө тууштай зүтгэж байна.

Monique “Moe” Bryant

Арлингтон дүүргийн Сургуулийн Зөвлөл

13 жилийн турш Арлингтон дүүргийн улсын сургуулийн (APS) сурагчийн эцэг байсан, мөн Арлингтоны төрийн бус байгууллагын удирдагч Моник “Мое” Брайнт нь сургууль болон олон нийтийн төлөө тууштай тэмцэгч гэдгээ нотолсон нэгэн юм. Мое нь сурагчид, багш нар, нийгэмлэгийн хувьд Арлингтон дүүргийн улсын сургуулийн (APS) амжилтыг өрөвч сэтгэл ба идэвхтэй оролцоонд тулгуурлан баталгаажуулахын төлөө ажиллана. Тэрээр 2024 оны APS сургуулийн бондын кампанит ажлыг хамтран ахалж, хэд хэдэн сургуульд сайн дурын ажил хийсэн билээ. Мое нь ‘Challenging Racism’ байгууллагын захирал бөгөөд Арлингтоны хамгийн хүнд асуудлуудыг холбож, хамтын шийдэлд хүрэхэд гүүр болж ажилладаг.

10-Р САРЫН 24-ӨӨС ӨМНӨ БҮРТГЭЛЭЭ ХИЙГЭЭРЭЙ!

Урьдчилан санал өгөх (биеэр):

2025 оны 9-р сарын 19–өөс 11-р сарын 1

Кортхаус Плаза, Сонгуулийн байр, 320-р өрөө

Даваа–Баасан: 9/19–10/31, 8:00–17:00 цагийн хооронд

Мягмар, Лхагва, Пүрэв (10/21–23 ба 10/28–30): 8:00–19:00 цагийн хооронд

Нэмэлт цаг болон байршлууд 10-р сарын 21

Кортхаус Плаза, Мэдисон Олон нийтийн төв,

ба Уолтер Рийд Олон нийтийн төв

10-р сарын 25 болон 11-р сарын 1-ний Бямба гараг: 09:00–17:00 | 10-р сарын 26-ны Ням гараг: 11:00–15:00

Мягмар, Лхагва, Пүрэв (10/21–23 ба 10/28–30): 14:00–19:00 цагийн хооронд

Шуудангаар санал өгөх

Шуудангийн саналын хуудсаа 10-р сарын 24-ний 17:00 цагаас өмнө хүсэлт өгөн авна уу

Саналын хуудсаа шуудангаар буцаах:

Шуудан 11-р сарын 4-ний Мягмар гарагт шуудангийн тэмдэгтэй байх ба 11-р сарын 7-ны Баасан гарагийн 12:00 цагаас өмнө хүлээн авсан байх ёстой. **Боломжтой бол аль болох эрт буцаагаарай — хүргэлт 10 хүртэл хоног зарцуулж болно.**

Саналын хуудсаа биеэр буцаах боломжууд:

- Аль ч санал авах байршилд 11-р сарын 4-ний 19:00 цагаас өмнө
- Аль ч урьдчилсан санал авах байршилд 11-р сарын 4-нөөс өмнө
- Аль ч 24/7 саналын хайрцагт 11-р сарын 4-ний 19:00 цагаас өмнө

Сонгогчийн үнэмлэх

Бүх сонгогчид санал өгөхдөө хүчинтэй үнэмлэхээ үзүүлэх эсвэл ID баталгаажуулалтын мэдэгдэлд гарын үсэг зурсан байх ёстой:

www.elections/virginia/gov

Дараалсан сонголттой санал өгөх

Саналын хуудсан дээр Такэс Карантонисыг #1-т жагсаагаарай.

Дараалсан сонголттой санал хураалтыг зөвхөн
Хорооны Зөвлөлийн сонгуульд ашиглана.

Санал өгөхөөр явахад унаа хэрэгтэй юу?

703-528-8588 утсаар болон
info@arlingtondemocrats.org хаягаар холбогдоорой.

Санал өгөх төлөвлөгөө гаргаарай. Санал өгөхдөө урьдчилан биеэр эсвэл шуудангаар санал өгч болно. Одоогийн хаяг дээрээ бүртгэлтэй байгаа эсэхээ шалгаарай. Санал хураалтын өдөр 11-р сарын 4 гэдгийг мартуузай.